



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 10 дугаар сарын 02-ны
өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/376

Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичгийн загварыг шинэчлэн батлах тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.17 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 1 дүгээр, Ус ашиглах эрхийн бичгийн загварыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Ус ашиглах эрхийн бичгийн хэвлэмэл хуудсыг нэгдсэн журмаар хэвлүүлж, холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Ш.Мягмар/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загвар батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-157 дугаар тушаал, “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/33 дугаар тушаал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/347 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Байгаль орчин, аялал
жуулчлалын сайдын 2018
оны 10 дугаар сарын 02-ны
өдрийн А/376 дугаар
тушаалын 1 дүгээр
хавсралт

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС /төгрөгөөр/

Усны хэрэглээ, м ³ /хоног						
50 хүртэлх	50-100	100-200	200-500	500-1000	1000-3000	3000-с дээш
50 000	100 000	560 000	645 000	790 000	845 000	1% *

* Тайлбар: Усны нөөц ашиглахад ногдуулсан төлбөрийн хэмжээнээс хувиар тооцно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын

2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн

А/376 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Соёмбо

УС АШИГЛАХ ЭРХИЙН БИЧИГ

Дугаар

.....

/Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн

.....-ын гаргасан 20оны-р сарын-ны өдрийн

Байгаль орчны алба/

дугаартай ус ашиглуулах дүгнэлт,

/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба,

.....-ЫН ОЛГОСОН

сум, дүүргийн Засаг дарга/

20 оны-р сарын-ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл,

/Сав газрын

захиргаа,

..... -тай

аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга, Ус хангагч байгууллага/

20 оны -р сарын -ны өдөр байгуулсан дугаар бүхий

ус ашиглах гэрээг үндэслэн аймаг, нийслэл,

..... сум, дүүрэг баг, хорооны

/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хаяг/

нутагт байршилтай, улсын бүртгэлийн тоот гэрчилгээтэй,

..... регистрийн дугаартай -Г

/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр/

ус ашиглахад тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж,

байршилтай усны нөөцөөс хоногт шоометр усыг

/гадаргын ус, газрын доорх ус/

..... зориулалтаар ашиглах ЭРХИЙН БИЧИГ-ийг
гурван жилийн хугацаагаар олгов.

Эрхийн бичиг олгосон:

.....

аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Байгаль хамгаалагч

/байгууллага, албан тушаалтны нэр, гарын үсэг/

20 оны -р сарын -ны өдөр

СУНГАЛТ

Сунгалт хийсэн шийдвэр	Он, сар, өдөр	Гарын үсэг, тамга

--	--	--

Тайлбар:

Ус ашиглах эрхийн бичгийг Улсын усны мэдээллийн санд бүртгэнэ.

Ус ашиглах эрхийн бичгийг бусдад ашиглуулах, худалдах, шилжүүлэхийг хориглоно.

